



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн “Чандмань илч” ОНӨХХК-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/14/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор:

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Аудитор:

Т.Ган-Өлзий

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Н.Түвшинбаатар

Цахим хаяг: tuvshinbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН | 5 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 8 |
| 5.1 Албан шаардлага | 8 |
| 5.2 Зөвлөмж | 9 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 10 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.03.13 № 1-6/309

танай _____ -ны № _____ -т

Г ЧАНДМАНЬ-ИЛЧ ОНӨХХК-ИЙН Г
ЗАХИРАЛ Д.ТӨМӨРБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Чандмань-Илч” ОНӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны 281 аж ахуй нэгжийн 735.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 20 аж ахуй нэгжийн 65.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 11 төсөл арга хэмжээг 4,486.8 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталснаас 257.6 сая төгрөгийн 6 ТАХ-г 05 сарын 31-ны өдрийн дотор худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулж дуусаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “батлагдсан төсөл арга хэмжээний

442505285

худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэж заалттай нийцэхгүй байна.

Тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийн шинж чанартай 6 нэр төрлийн 9 ширхэг 51,465,490.64 төгрөгийн хөрөнгийн бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Ерөнхий нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээнэ", НББОУС-16-д "Үндсэн хөрөнгө гэдэг нь нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж хөрөнгө бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл болон нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын зориулалтаар ашиглагдах хөрөнгийг хэлнэ", "мөн үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн, Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн аж ахуйн нэгжид орох магадлалтай байх, Өртгийг нь найдвартай хэмжих боломжтой байх шалгуурыг хангасан хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцэхгүй байна.

2023.11.13-ны өдрийн 136/ШШ2023/00524 дугаар шүүгчийн захирамжаар 1 ажилтанд хууль бусаар ажлаас халсан тогтоогдож ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулахаар шийдвэрлэсэн ба 2024 оны 2 дугаар сард тус захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилгүй байсан хугацааны цалин 10,500,000 төгрөгийг байгууллагын төсвөөс олгож буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", 50.2-т "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана" гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|---------------|---------------------------------------|--------------------------|--------------------------|
| | | 1 сарын 1 | 12 сарын 31 |
| 1.1.01 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 824,159,661.85 | 1,204,111,804.76 |
| 1.1.02 | Дансны авлага | 1,229,088,917.59 | 1,183,550,422.99 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 904,670.00 | 13,192,994.33 |
| 1.1.04 | Бусад авлага | 193,085,380.70 | 16,161,316.93 |
| 1.1.06 | Бараа материал | 2,043,585,547.27 | 1,834,017,891.91 |
| 1.1.07 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 2,265,939,202.24 | 1,032,362,200.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 6,556,763,379.65 | 5,283,396,630.92 |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 49,453,904,510.19 | 48,819,832,256.99 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 2,626,474,865.79 | 2,747,748,323.71 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 52,080,379,375.98 | 51,567,580,580.70 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 58,637,142,755.63 | 56,850,977,211.62 |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 2,353,675,224.97 | 3,709,193,614.54 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | 471,661,750.00 | 518,514,000.00 |
| 2.1.1.03 | Татварын өр | 1,303,032,568.50 | 714,037,925.55 |
| 2.1.1.04 | НДШ - ийн өглөг | 184,976,226.38 | 698,994,097.77 |
| 2.1.1.08 | Урьдчилж орсон орлого | 1,263,751,863.26 | 57,733,493.55 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 5,577,097,633.11 | 5,698,473,131.41 |
| 2.1.2.01 | Урт хугацаат зээл | 1,918,465,293.49 | 1,918,465,293.49 |
| 2.1.2.04 | Бусад урт хугацаат өр төлбөр | 38,564,024,425.18 | 38,671,304,442.91 |
| 2.1.2.06 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 40,482,489,718.67 | 40,589,769,736.40 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 46,059,587,351.78 | 46,288,242,867.81 |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 15,459,856,685.46 | 15,459,856,685.46 |
| 2.3.06 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 7,388,629,707.44 | 7,301,744,586.64 |
| 2.3.08 | Эздийн өмчийн бусад хэсэг | 521,700,701.20 | 521,700,701.20 |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | -10,792,631,690.25 | -12,720,567,629.49 |
| 2.3.09.1 | Тайлангийн үеийн ашиг | 0.00 | -2,014,821,060.04 |
| 2.3.09.2 | Өмнөх үеийн ашиг | -10,792,631,690.25 | -10,705,746,569.45 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 12,577,555,403.85 | 10,562,734,343.81 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 58,637,142,755.63 | 56,850,977,211.62 |

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---------------|--|-------------------|--------------------|
| 01 | Борлуулалтын орлого (цэвэр) | 22,867,232,581.52 | 15,095,764,949.46 |
| 02 | Борлуулалтын өртөг | 27,088,784,313.29 | 20,710,413,429.29 |
| 03 | Нийт ашиг(алдагдал) | -4,221,551,731.77 | -5,614,648,479.83 |
| 04 | Түрээсийн орлого | 19,602,005.52 | 38,454,545.55 |
| 05 | Хүүний орлого | 3,769,148.27 | 2,230,592.48 |
| 06 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 07 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 08 | Бусад орлого | 4,530,829,936.44 | 5,394,980,216.86 |
| 08.1 | Орлогын дүн | 4,554,201,090.23 | 5,435,665,354.89 |
| 09 | Борлуулалт, маркетингийн зардал | 13,933,638.15 | 6,086,861.13 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,465,199,644.27 | 1,768,584,139.14 |
| 11 | Санхүүгийн зардал | 0.00 | 0.00 |
| 12 | Бусад зардал | 48,020,926.31 | 43,969,868.75 |
| 12.1 | Зардлын дүн | 1,527,154,208.73 | 1,818,640,869.02 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | -873,638.97 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | -6,670,110.18 | -16,100,367.84 |
| 17.1 | Олз, гарзын дүн | -6,670,110.18 | -16,974,006.81 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) | -1,201,174,960.45 | -2,014,598,000.77 |
| 19 | Орлогын татварын зардал | 376,914.83 | 223,059.27 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | -1,201,551,875.28 | -2,014,821,060.04 |
| 21 | Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | 0.00 | 0.00 |

**Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ОНӨХХК -ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

| | | | |
|------|---|-------------------|-------------------|
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | -1,201,551,875.28 | -2,014,821,060.04 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.3 | Бусад олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 24 | Орлогын нийт дүн | 0.00 | 0.00 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмч | Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|---|-------------------|---------------------------------|---------------------------|--------------------|-------------------|
| 01 | 2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 15,459,856,685.46 | 7,388,629,707.44 | 521,700,701.20 | -9,591,079,814.97 | 13,779,107,279.13 |
| 02 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 03 | Залруулсан үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 04 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | -1,201,551,875.28 | -1,201,551,875.28 |
| 05 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 06 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 07 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 08 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 09 | 2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 15,459,856,685.46 | 7,388,629,707.44 | 521,700,701.20 | 10,792,631,690.25 | 12,577,555,403.85 |
| 10 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 86,885,120.80 | 86,885,120.80 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | -2,014,821,060.04 | -2,014,821,060.04 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | -86,885,120.80 | 0.00 | 0.00 | -86,885,120.80 |
| 17 | 2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл | 15,459,856,685.46 | 7,301,744,586.64 | 521,700,701.20 | 12,720,567,629.49 | 10,562,734,343.81 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|--|-------------------|-------------------|
| 0 | Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 18,833,387,884.10 | 22,466,740,464.84 |

**Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ОНӨХХК -ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

| | | | |
|-------|--|-------------------|-------------------|
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 16,108,769,788.10 | 16,953,083,491.24 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 0.00 | 0.00 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 2,721,292,316.00 | 5,295,000,000.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 3,325,780.00 | 218,656,973.60 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 18,790,387,690.96 | 22,089,018,914.41 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 5,838,404,962.23 | 7,367,385,358.45 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,793,116,846.50 | 1,785,000,000.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 5,765,743,935.69 | 6,397,980,408.16 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 1,999,936,115.77 | 2,619,059,057.86 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 1,481,823,599.59 | 1,330,375,751.45 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 2,500,000.00 | 0.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 1,156,348,957.61 | 2,196,411,049.84 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 10,092,032.40 | 18,629,700.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 742,421,241.17 | 374,177,588.65 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 43,000,193.14 | 377,721,550.43 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 3,769,148.27 | 2,230,592.48 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 3,769,148.27 | 2,230,592.48 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 3,769,148.27 | 2,230,592.48 |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 57,498,531.70 | 0.00 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 57,498,531.70 | 0.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -57,498,531.70 | 0.00 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -10,729,190.29 | 379,952,142.91 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 834,888,852.14 | 824,159,661.85 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 824,159,661.85 | 1,204,111,804.76 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| | | | | /мянган төгрөгөөр/ | |
|------------|--------------------------|----------------------|---------------------|--------------------|---------|
| Дд | Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| | ОРЛОГО | | | | |
| 1 | Үндсэн үйл ажиллагаа | 14,791,884.85 | 14,624,230.5 | 167,654.4 | 98.9% |
| 1.1 | Дулааны орлого | 11,832,683.90 | 11,447,588.2 | 385,095.7 | 96.7% |
| 1.1.1 | Төсөвт байгууллага | 7,668,271.20 | 7,222,541.9 | 445,729.3 | 94.2% |
| 1.1.2 | ААНБ | 2,249,910.10 | 2,371,558.0 | (121,647.9) | 105.4% |
| 1.1.3 | Орон сууц | 1,686,602.60 | 1,611,635.5 | 74,967.1 | 95.6% |
| 1.1.4 | Хэрэглээний халуун ус | 29,000.00 | 36,582.5 | (7,582.5) | 126.1% |
| 1.1.5 | Суурь хураамж | 198,900.00 | 205,270.3 | (6,370.3) | 103.2% |
| 1.2 | Цэвэр усны орлого | 1,585,100.95 | 1,795,790.4 | (210,689.4) | 113.3% |
| 1.2.1 | Төсөвт байгууллага | 440,700.00 | 412,468.7 | 28,231.3 | 93.6% |
| 1.2.2 | ААНБ | 257,612.40 | 317,243.0 | (59,630.6) | 123.1% |
| 1.2.3 | Орон сууц | 626,280.00 | 663,260.8 | (36,980.8) | 105.9% |
| 1.2.4 | Зөөвөр | - | 61,129.7 | (61,129.7) | |
| 1.2.5 | УТБ | 68,925.35 | 61,642.1 | 7,283.3 | 89.4% |
| 1.2.6 | Суурь хураамж | 182,079.20 | 185,917.9 | (3,838.7) | 102.1% |
| | Цэвэр усны төв | 9,504.00 | 94,128.2 | (84,624.2) | 990.4% |
| 1.3 | Бохир усны орлого | 1,374,100.00 | 1,380,851.9 | (6,751.9) | 100.5% |
| 1.3.1 | Төсөвт байгууллага | 354,254.80 | 382,854.9 | (28,600.1) | 108.1% |
| 1.3.2 | ААНБ | 231,632.40 | 269,065.0 | (37,432.6) | 116.2% |
| 1.3.3 | Орон сууц | 634,210.60 | 587,240.8 | 46,969.8 | 92.6% |
| 1.3.4 | Зөөвөр | 24,000.00 | 97,367.0 | (73,367.0) | 405.7% |
| | Суурь хураамж | 46,842.20 | 44,324.3 | 2,517.9 | 94.6% |
| | Төмөр замын бохир | 83,160.00 | - | 83,160.0 | 0.0% |
| 2 | Бусад | 379,540.00 | 5,920,181.8 | (5,540,641.8) | 1559.8% |
| 2.1 | Татаас | - | 3,204,071.9 | (3,204,071.9) | |
| 2.2 | Цайны газар | 40,000.00 | 26,800.0 | 13,200.0 | 67.0% |
| 2.3 | Засвар, үйлчилгээ | 150,000.00 | 140,869.7 | 9,130.3 | 93.9% |
| 2.4 | Техникийн нөхцөл | 20,000.00 | 25,098.2 | (5,098.2) | 125.5% |

**Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ОНӨХХК -ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

| | | | | | |
|-------|--------------------------------|----------------------|-----------------------|----------------------|---------------|
| 2.5 | Маягтны үнэ | 5,000.00 | 10,033.9 | (5,033.9) | 200.7% |
| 2.6 | Нүүрс | 80,000.00 | 92,810.0 | (12,810.0) | 116.0% |
| 2.7 | Шатахуун | - | 118.9 | (118.9) | |
| 2.8 | Авто үйлчилгээ | 30,000.00 | 5,946.2 | 24,053.8 | 19.8% |
| 2.9 | Санхтехник зүүхны материал | 20,000.00 | 142,696.7 | (122,696.7) | 713.5% |
| 2.10. | Хангамжийн материал /БҮТЭЦ/ | 15,000.00 | 10,009.1 | 4,990.9 | 66.7% |
| 2.11 | Түрээс | 9,540.00 | 38,454.5 | (28,914.5) | 403.1% |
| 2.13 | Бусад | 10,000.00 | 17,151.7 | (7,151.7) | 171.5% |
| 3 | Үндсэн бус үйл ажиллагаа | - | 2,206,120.9 | (2,206,120.9) | |
| 4 | Хөнгөлөлт | (100,000.00) | (7,453.5) | (92,546.5) | 7.5% |
| | НИЙТ ОРЛОГЫН ДҮН | 15,071,424.84 | 20,536,958.737 | (5,465,533.9) | 136.3% |
| | ЗАРДАЛ | - | - | - | |
| 1 | ББӨ | - | 165,013.7 | (165,013.7) | |
| 2 | Цалин | 10,147,316.00 | 8,915,554.2 | 1,231,761.8 | 87.9% |
| 3 | ТУЗ-ын нарийн бичгийн цалин | 16,200.00 | - | 16,200.0 | 0.0% |
| 4 | ТУЗ-ын урамшуулал | 14,400.00 | 3,200.0 | 11,200.0 | 22.2% |
| 5 | НДШ | 1,547,548.30 | 1,291,103.8 | 256,444.5 | 83.4% |
| 6 | Үндсэн түүхий эд материал | 3,867,430.10 | 3,427,644.2 | 439,785.9 | 88.6% |
| 7 | Хангамжийн материал | 82,702.50 | 88,257.9 | (5,555.4) | 106.7% |
| 8 | Бичиг хэрэг | 20,541.70 | 25,699.9 | (5,158.2) | 125.1% |
| 9 | Хөдөлмөр хамгаалал | 388,479.50 | 444,972.9 | (56,493.4) | 114.5% |
| 10 | Шууд бус материал | 107,202.79 | 74,174.34 | 33,028.5 | 69.2% |
| 11 | Цахилгаан | 2,224,318.67 | 2,053,808.0 | 170,510.6 | 92.3% |
| 12 | Интернет, шуудан холбоо | 46,380.50 | 42,675.6 | 3,704.9 | 92.0% |
| 13 | Тээвэр | - | 157,397.5 | (157,397.5) | |
| 14 | Шатах тослох материал | 653,265.70 | 496,463.6 | 156,802.1 | 76.0% |
| 15 | Хог хаягдал /үйлчилгээний хөлс | 3,820.00 | 2,000.0 | 1,820.0 | 52.4% |
| 16 | Газрын төлбөр | 8,154.00 | 15,181.9 | (7,027.9) | 186.2% |
| 17 | Усны төлбөр | 17,381.76 | 23,404.5 | (6,022.7) | 134.6% |
| 18 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,798.10 | 3,274.4 | 523.7 | 86.2% |
| 19 | Хөрөнгийн татвар | 36,156.00 | 37,418.0 | (1,262.0) | 103.5% |
| 20 | Даатгал | 10,476.60 | 10,000.0 | 476.6 | 95.5% |
| 21 | Агаарын бохирдлын төлбөр | 2,201.90 | 2,387.2 | (185.3) | 108.4% |
| 22 | Урсгал ЗАСВАР | 1,000,000.00 | 1,031,561.6 | (31,561.6) | 103.2% |
| 23 | Элэгдэл | 3,613,572.80 | 3,487,664.1 | 125,908.7 | 96.5% |
| 24 | ТЗЭ Үйлчилгээний хураамж | 129,443.00 | 174,016.2 | (44,573.2) | 134.4% |
| 25 | Програм ашиглалтын зардал | 78,682.00 | 71,648.6 | 7,033.4 | 91.1% |
| 26 | Томилолт | 65,580.00 | 46,864.8 | 18,715.2 | 71.5% |
| 27 | Зам арчлалт | 70,000.00 | 78,015.8 | (8,015.8) | 111.5% |
| 28 | Бусад | 107,750.00 | 97,407.1 | 10,342.9 | 90.4% |
| 29 | Зар сурталчилгаа | 4,400.00 | 6,000.0 | (1,600.0) | 136.4% |
| 30 | Сургалт | 56,500.00 | 18,010.4 | 38,489.6 | 31.9% |
| 31 | Банкны шимтгэл | 1,000.00 | 0.2 | 999.8 | 0.0% |
| 32 | Үйл ажиллагааны бус | 77,345.00 | 24,382.6 | 52,962.4 | 31.5% |
| 33 | ҮАЗ Шагнал урамшуулал | 30,000.00 | 1,462.6 | 28,537.4 | 4.9% |
| 34 | ҮАЗ тэтгэмж буцалтгүй тусламж | 67,824.70 | 35,978.3 | 31,846.4 | 53.0% |
| 35 | ҮАЗ Тэмцээн баяр ёслол | 34,500.00 | 32,461.5 | 2,038.5 | 94.1% |
| 36 | Түрээс | 1,000.00 | 400.0 | 600.0 | 40.0% |
| 37 | Их засвар | - | 166,274.6 | (166,274.6) | |
| | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 24,535,371.62 | 22,551,779.796 | 1,983,591.8 | 91.9% |
| 1 | Татварын өмнөх ашиг | (9,463,946.78) | (2,014,821.06) | (7,449,125.7) | 21.3% |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 127.7 сая төгрөгийн 4 алдаа¹, зөрчил илэрснээс 65.7 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 62.0 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Тайлант онд 281 аж ахуй нэгжийн 735.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 20 аж ахуй нэгжийн 65.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

5.2 Зөвлөмж

1. Тайлант онд 11 төсөл арга хэмжээг 4,486.8 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталснаас 257.6 сая төгрөгийн 6 ТАХ-г 05 сарын 31-ны өдрийн дотор тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулж дуусаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “*батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах*” гэж заалттай нийцэхгүй байна.

Үр дагавар: Батлагдсан төсөв үр ашиггүй зарцуулагдах, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, батлагдсан ТАХ-ний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн зохион байгуулж дуусгах;

2. Тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийн шинж чанартай 6 нэр төрлийн 9 ширхэг 51,465,490.64 төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална*”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “*Ерөнхий нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээнэ*”, НББОУС-16-д “*Үндсэн хөрөнгө гэдэг нь нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж хөрөнгө бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл болон нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын зориулалтаар ашиглагдах хөрөнгийг хэлнэ*”, “*мөн үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн, Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн аж ахуйн нэгжид орох магадлалтай байх, Өртгийг нь найдвартай хэмжих боломжтой байх шалгуурыг хангасан хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө*” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмыг хангаж, Үндсэн хөрөнгийг НБББББ-т заасан холбогдох дансанд бүртгэж ашиглалтын хугацаагаар элэгдүүлж хэвших;

3. Шүүгчийн 2023.11.13-ны өдрийн 136/ШШ2023/00524 дугаар захирамжаар 1 ажилтныг хууль бусаар ажлаас халсан тогтоогдож ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулахаар шийдвэрлэсэн ба 2024 оны 2 дугаар сард тус захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилгүй байсан хугацааны цалин 10,500,000 төгрөгийг байгууллагын төсвөөс олгож буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “*Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ*”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т “*Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ*”, 50.2-т “*Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана*” гэж заасантай нийцэхгүй байна.

Үр дагавар: Батлагдсан төсөв үр ашиггүй зарцуулагдах, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж: Хууль бусаар ажлаас халагдсан албан хаагчийн төсвөөс олгосон 10,500,000 төгрөгийн цалинг буруутай этгээдээс гаргуулах ажлыг зохион байгуулж Төрийн албаны зөвлөл болон хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж, байгууллагын төсвийг хохиролгүй болгох;

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|-----------------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Авллага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй | 1 | 65,742.5 | | | 1 | 65,742.5 | | | | | | |
| Үндэслэлгүй ажлаас халсан нь тогтоогдож ажилгүй байсан хугацааны цалинг байгууллагаас төлсөн | 1 | 10,500.0 | | | | | 1 | 10,500.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн | 1 | 51,465.5 | | | | | 1 | 51,465.5 | | | | |
| Дүн | 3 | 127,707.9 | | | 1 | 65,742.5 | 2 | 61,965.5 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | |
|---|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|----------|----------|--------------------------------------|---------------------|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй | 1 | - | | | | | 1 | - | | | |
| Дүн | 1 | - | | | | | 1 | - | | | |

Дээрх албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.